



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 6/47

Улаанбаатар хот

Н.Нармандахыг ажлаас халах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 38.1.2, 40.1.4, 40.1.5, 43.1, 131.1.3, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5, Захиргааны ерөнхий хуулийн 26.1, Архивын ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.1, 5.1, 5.2.1, 5.2.7, 5.3, 5.5, 13.1, 13.2, Н.Нармандахтай байгуулсан Б-х-09 дугаартай хөдөлмөрийн гэрээний 13.1, 13.1.4, 13.1.9, 2019 оны 03 сарын 29-ний өдрийн мэдэгдэл танилцуулсан тэмдэглэл, 2019 оны 04 сарын 04-ний өдрийн сонсох ажиллагааны мэдэгдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн гэрээт жолооч Норовын Нармандах нь Хөдөлмөрийн гэрээний 9.1, 9.3, 13.1.4, 13.1.9-ийг удаа дараа зөрчиж 2019 оны 3 дугаар сарын 16-ны өдөр ажил үүргээ гүйцэтгэж явахдаа согтууруулах ундаа хэрэглэсэн нь албан хаагчдын тайлбараар, мөн байгууллагад 821,421 /найман зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун хорин нэгэн/ төгрөгийн хохирол учруулсан болох нь 2019 оны 03 сарын 14-ний өдрийн Дотоод аудитын шалгалтаар тус тус нотлогдож байх тул түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг 2019 оны 04 сарын 05-ны өдрөөр тасалбар болгон цуцалж, ажлаас нь халсугай.

2. Н.Нармандахтай ээлжийн амралтын болон санхүү аж ахуйн бусад төлбөр тооцоог хийж дуусган, ажлыг зохих журмын дагуу хүлээн авахыг Санхүү, аж ахуйн хэлтэс /Б.Цэвэлмаа/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /Л.Уянга/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү шийдвэрийг ажилтан үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж болохыг дурдсугай.

ДАРГА  С.ЭНХБААТАР

Tushaal

368110276